



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 14 өдөр

Дугаар А/291

Арвайхээр

Хагас жилийн малын түүвэр судалгааг  
зохион байгуулах ажлын хэсэг байгуулах  
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.г, Статистикийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.в, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хагас жилийн малын түүвэр судалгааг зохион байгуулах аймгийн ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: И.Доржсүрэн (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: О.Түмэнжаргал (Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн дарга)

С.Цэдэнбалжир (Аймгийн Засаг даргын дэргэдэх Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)

А.Нямдаваа (Аймгийн Засаг даргын дэргэдэх Мал эмнэлгийн газрын дарга)

Нарийн бичгийн дарга: Э.Лхамсүрэн (Аймгийн Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийн мэргэжилтэн)

2. Хагас жилийн малын түүвэр судалгааны ажлын хэсгийг сумдад байгуулж, судалгааг чанартай явуулахад чиглэсэн бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг сум, багийн түвшинд хангуулах, судалгааны тоологч нарыг сургах, түүвэр судалгаанд ажиллуулах томилогдсон хүмүүсийн халдвар хамгааллын дэглэмийг сахин ажиллах хариуцлагыг өндөржүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах, судалгааны дүнг мэдээллийн санд шивж оруулах ажлыг удирдан зохион байгуулах, хагас жилийн түүвэр судалгааны мэдээлэл цуглуулалтыг 2021 оны 06 дугаар сарын 15-аас 22-ны хооронд зохион байгуулж, хяналтын тооллого хийж, дүн мэдээллийг хугацаанд нь хүлээлгэн өгөхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Малын түүвэр судалгааны бэлтгэл, зохион байгуулалтын ажлыг аймаг, сумын түвшинд хангаж, судалгааг тогтоосон хугацаанд заавар, журмын дагуу чанартай явуулж, дүнг мэдээлэхийг ажлын хэсгийн ахлагч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100622